

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**ОЧИР УНДРАА ОМЗ ББСБ ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД****Санхүүгийн Тайлангийн Аудитын Тайлан****Дүгнэлт**

Бид, Очир Ундраа ОМЗ ББСБ ХХК-ийн (цаашид Компани гэх) 2023 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулга, тэмдэглэлээс бүрдсэн *санхүүгийн тайланд* аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, Компанийн 2023 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээ нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан журам, зааврын дагуу, бүх материаллаг зүйлийг хамруулан үнэн зөв толилуулагдсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын Ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЁЗОУСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын Аудитын тухай хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЁЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж найдаж байна.

Бусад асуудал


Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Очир Ундраа ОМЗ ББСБ ХХК-ийн Монгол улсын Компанийн тухай хуулийн 5-р зүйлд заасан хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргасан бөгөөд бусад этгээдэд зориулагдаагүй болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд гуравдагч этгээдийн өмнө хариуцлага хүлээхгүй болно.



Хаяг: Улаанбаатар хот 14240, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж 7/3 байр, Centrum төв, 7 давхар 701 тоот.

Утас: 976-70150003, И-мэйл: info@moore-mongolia.mn

ОЧИР УНДРАА ОМЗ ББСБ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН

		Аудитлагдсан 2023.12.31 Мян.төг	Аудитлагдсан 2022.12.31 Мян.төг
	Тод		
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	15	2,649,940	2,711,966
Биет бус хөрөнгө	16	169,113	190,222
Нийт эргэлтийн бус хөрөнгө		2,819,053	2,902,188
Эргэлтийн хөрөнгө			
Бусад хөрөнгө	19	449,337	491,330
Харилцагчдад олгосон зээл /Цэвэр/	18	57,303,393	42,580,599
Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлага	20	1,000,373	863,499
Бусад авлага	20	386,054	149,527
Богино хугацаат хөрөнгө оруулалт	17	24,314	99,420
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	21	4,203,547	3,498,131
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	22	307,740	-
Нийт эргэлтийн хөрөнгө		63,674,758	47,682,506
НИЙТ ХӨРӨНГӨ		66,493,811	50,584,694
			
ЭЗДИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР			
Эздийн өмч			
Хувьцаат капитал	23	2,500,000	2,500,000
Эздийн өмчийн бусад хэсэг	25	700,934	684,733
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	24	39,234,977	32,507,762
Нийт эздийн өмч		42,435,911	35,692,495
Богино хугацаат өр төлбөр			
Зээллэг	26	-	-
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	27	21,856,850	13,426,739
Хуримтлуулж тооцсон үр шимийн өглөг	27	1,351,413	1,061,466
Бусад өр төлбөр	27	849,637	403,994
Нийт богино хугацаат өр төлбөр		24,057,900	14,892,199
Нийт өр төлбөр		24,057,900	14,892,199
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР		66,493,811	50,584,694
			

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.